




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ  
ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДДАГ ӨРХИЙН  
ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
СУДАЛГАА-2023

Олонлог судалгаа аргачлалын төв ТББ-ын судлаачид

Д. Больтогтох  
Б. Бадамхүү  
Ж. Номин-Эрдэнэ



# Зорилго, зорилтууд

Энэхүү судалгаа нь ХТДҮҮ-нд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, цаашид эдгээр гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэхэд зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлуудыг илрүүлэх зорилготой.

1



Зорилт 1

Өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, орлогын бүтэц болон мөнгөн тэтгэмжийн өрхийн орлогод эзлэх хувь нэмрийг өрхийн тэргүүний нас, амьдарч буй нөхцөл, өрхийн гишүүдийн бүтэц, өрх толгойлсон байдал, хөдөлмөр эрхэлж буй гишүүдийн тоо зэрэг категориудаар ялгах

2



Зорилт 2

Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, тулгамдаж буй бэрхшээл, өнөөгийн хэрэгцээ шаардлага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны сэтгэл ханамжийг боловсрол, мэргэжил, насны ангилал, хүйс, ажил олгогчийн статус, бусад онцлог, хөдөлмөр эрхлэлтийн төрөл зэргээр ялган судлах

3



Зорилт 3

ХТДҮҮ-нд хамрагддаг өрхүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжуудыг судлах

4




Зорилт 4

Судалгаагаар гарсан үр дүнд тулгуурлан дүгнэлт, санал зөвлөмж өгөх

# Судалгааны хүрээ, арга зүй

Нийслэлийн 9 дүүрэг дэх ХТДҮҮ-нд хамрагддаг өрхүүдийн хөдөлмөрийн насны гишүүдийг олон шатлалт, бүлэглэсэн түүвэрлэлтийн аргаар сонгож хамруулсан бөгөөд түүврийн үндсэн нэгж нь өрхийн насанд хүрсэн гишүүн болно. Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэсэн.

01




Тоон судалгааг хийхдээ асуумжийн аргаар Кобо аппликейшныг ашиглан мэдээллийг цуглуулсан ба асуумж нь өрхийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл, хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны өнөөгийн байдлыг үнэлэх агуулгатай 3 бүлэг, 60 асуулттай.

Чанарын судалгааг хийхдээ фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан ба 3 бүлгийг оролцуулсан.



02

03



Судалгааны мэдээллийн боловсруулалтад SPSS, Excel, Eviews програмуудыг ашигласан ба тодорхойлогч болон дүгнэлтийн статистикууд, эконометрикийн загварууд тодорхойлсноор тархалт болон нөлөөллийг үнэлж, дүгнэсэн.

2023 оны 6 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд ХТДҮҮ-нд 68,609 иргэн хамрагдаж байгаа бөгөөд 95 хувийн магадлалтайгаар 381 иргэн судалгаанд хамрагдах тооцоо гарсан.



04

# Түүвэрлэлт

## Хөдөлмөрийн насны хүний тоог харгалзах

Дүүрэг бүрийн ХТДҮҮ-нд хамрагддаг, хөдөлмөрийн насны иргэдийн эзлэх хувьд харгалзуулан 381 иргэнийг хуваасан. Мэдээлэл цуглуулалтын явцтай холбогдуулан сүүлийн өдрүүдэд Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргээс бусад дүүрэгт цөөн иргэнийг шилжүүлсэн.

## ХТДҮҮ-нд хамрагддаг иргэдийн тоог харгалзах

ХТДҮҮ-нд хамрагддаг өрх олонтой дүүрэг болох Сонгинохайрхан дүүргийг 3, Баянзүрх дүүргийг 2 кластер, бусад дүүргийг 1 кластер болгон, нийт 12 кластер үүсгэсэн. Кластер бүрээс 25 болон түүнээс дээш тооны өрх нь ХТДҮҮ хөтөлбөрт хамрагддаг 1 хороог сонгосон.

## Хөдөлмөрийн насны гишүүдийн насны ангиллыг харгалзах

Хөдөлмөрийн насны иргэдийг насны ангилал тус бүрт эх олонлогийн насны тархалттай ойролцоо хувиар хамруулсан.

Дүүрэг	Хамрагдсан хорооны дугаар	Байршил, хамрагддаг хэсгүүд	ХТДҮҮ-нд хамрагдсан өрхийн тоо
Багануур	4	Багануур	92
Багахангай	1	Багахангай	26
Баянгол	23	3-р хорооллын арын гэр хороолол	36
Баянзүрх	23	Улиастай	190
	35	Улиастайн шинэ эцэс	152
Налайх	1	Налайх	77
Сонгинохайрхан	26	Их наран	572
	22	Баруун салаа	462
	7	Баянхошуу	333
Сүхбаатар	16	Дамбадаржаа	118
Хан-Уул	8	Яармаг	116
Чингэлтэй	16	Хайлааст	189

Үзүүлэлт	15-24 нас	25-34 нас	35-44 нас	45-55 нас	56-60 нас
Эх олонлогт эзлэх хувь	42.2%	15.2%	22.6%	16.4%	3.6%
Түүвэрт эзлэх хувь	32.8%	16.4%	28.1%	19.1%	3.6%





Үр дүн

# Үр дүн

Судалгааны зорилготой холбоотойгоор тоон болон чанарын судалгааны үр дүнг 4 үндсэн чиглэлээр харуулсан болно.



Өрхийн төлөөлөл болон салбарын экспертүүдийн ярилцлагын үр дүн



Өрхийн орлогын бүтэц, орлого нөлөөлөх хүчин зүйлс




Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлт



Өрхийн нийгмийн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал



# 1. Өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт




# 2. Хөдөлмөрийн насны гишүүд





### 3. Өрхийн орлогын бүтэц



#### Орлогын ангилалд өрхийн эзлэх хувь

Бүх өрх тэтгэмжийн орлоготойгоос гадна нийт өрхийн 80.8% нь цалингийн, 25.5% нь тэтгэврийн орлоготой бөгөөд 6.3% нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн орлого олсон байна.

#### Орлогын хэмжээ

Өрхийн сарын нийт орлого дунджаар 1,734,667 төгрөг. Харин нэг гишүүнд ногдох сарын орлогыг авч үзвэл дундаж нь 313,586 төгрөг байна.

#### Тэтгэмжийн хэмжээ

Өрхүүд сар бүр багадаа 24,000 төгрөг, ихдээ 1,722,000 төгрөг, дунджаар 513,766.9 төгрөгийн тэтгэмжийг төрөөс хүлээн авч байна.

### 3. Цалингийн орлого

Дүүрэг	Хүний тоо	Доод	Дээд	Дундаж	Вариацийн коэффициент
Багануур	8	537,000	900,000	692,125	15.5%
Багахангай	4	700,000	1,500,000	925,000	41.5%
Баянгол	12	500,000	2,000,000	929,167	44.5%
Баянзүрх	47	420,000	1,800,000	928,511	39.7%
Налайх	19	500,000	2,000,000	931,579	45.1%
Сонгинохайрхан	180	290,000	3,000,000	914,944	50.5%
Сүхбаатар	40	300,000	3,000,000	1,256,000	69.3%
Хан-Уул	37	290,000	3,000,000	894,054	49.2%
Чингэлтэй	88	300,000	3,000,000	929,625	46.9%
Нийт	435	290,000	3,000,000	946,078	52.7%

ХАМГИЙН БАГА

290'000₮

ХАМГИЙН ӨНДӨР

3'000'000₮

ДУНДАЖ

946'078₮

## 4. Экспертийн ярилцлага

### Өрхийн ТҮВШИН

- › Иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд цалин хөлсний хэмжээ болон тухайн хүний сэтгэл зүйн байдал хамгийн их нөлөөлж байгаа бол удаах нь иргэний нас болон нийгэм, эдийн засгийн байдал нөлөөлж байна гэж үзсэн.
- › Хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд, тулгардаг бэрхшээлийн тэргүүлэх шалтгааныг нэгд, ажилдаа ирж очиход цаг их зарцуулдаг, хоёрт нэг байгууллагад тогтвортой ажилладаггүй, гуравт, ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан хагас цагаар ажиллах шаардлагатай байдаг, түүнчлэн ур чадвар багатайгаас бага цалинтай ажил хийдэг гэжээ.
- › Хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн хувьд, ажил идэвхтэй хайдаггүй, ихэвчлэн бага дунд боловсролтой, асаргаа шаардлагатай өрхийн гишүүнтэй, бага насны хүүхдээ хардаг зэрэг шалтгаанууд нь хөдөлмөр эрхлэхэд тулгамдсан бэрхшээл аж.
- › Цаашид иргэдийг сэтгэл зүйн сургалтад хамруулах, оролцоог нэмэгдүүлэх нь чухал гэж үзсэн.

### Салбарын ТҮВШИН

- › Нэг мэргэжилтэн 1'237-14'000 хүртэлх тооны иргэдэд хүрч ажилладаг.
- › Халамжийн үйлчилгээнд ажлын цагийн 77%-ийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 23%-ийг зарцуулдаг.
- › Чиг үүргийнхээ хүрээнд иргэдэд мэдээлэл туслалцаа үзүүлэх, тайлан мэдээ бэлтгэж хүргүүлэх, нийтлэг үйлчилгээ төсөл хөтөлбөрт хамруулахад хамгийн их цагаа зарцуулдаг бол шинэ ажлын байр бүртгэх, сул орон тооны бааз үүсгэх, ажил хайгчийг бүртгэхэд хамгийн бага цаг зарцуулж байна.
- › Мэргэжилтнүүд төрийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнг дунджаар 68%-тай үнэлсэн ба ингэхдээ эмэгтэйчүүд болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хамгийн сайн буюу тус бүр 78%, ХБИ ажлын байрыг дэмжих хөтөлбөр хамгийн муу буюу 52% хэрэгжсэн гэж үнэлсэн.
- › ОУБ, ТББ-ууд мэргэжлийн чиг баримжаа олгох, өрхийн үйлдвэрлэлийг дэмжихэд түлхүү анхаарч ажилладаг боловч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар төрийн байгууллагад мэдээллэдэггүй, нэг удаагийн дэмжлэг үзүүлдэг, үйл ажиллагаагаа цөөн буюу сонгогдсон өрхүүд дээр хэрэгжүүлдэг зэрэг дутагдалтай талуудтай.
- › Цаашид ажил олгогчтой хамтрах, гэрээсээ ажиллах болон гэрт ойр, хагас цагийн ажлын байруудыг нэмэгдүүлэх нь чухал гэж үзсэн.

## 4. Бүлгийн ярилцлага

### Ажил олгогчийн шаардлага өндөр

- Нас заадаг тул 40 дээш ажил олоход хэцүү.
- Шинэ төгсөгчдийг туршлагагүй гээд авдаггүй.

### Ажил олгогчийн хариуцлага муу

- Цалингаа хугацаандаа болон бүрэн өгдөггүй.
- Гэрээний үүргээ биелүүлдэггүй болон гэрээ хийдэггүй.
- Үнэлгээ муу, урт цагаар ажиллахыг хүсдэг.

### Ар гэрийн нөхцөл байдал нийцдэггүй

- Алслагдсан байршилтай тул ажил тараад унаагүй болдог.
- Олон хүүхэдтэй, асаргаа шаардлагатай гишүүнтэй тул урт цагаар ажиллах боломжгүй.

### Ур чадвар дутмаг

- Дунд эргэм насныханд мэдлэг, боловсрол дутмаг байна.
- Залуу үеийнхэн боловсролтой хэдий ч, эзэмшсэн чадвар бага байна гэж үзсэн.

### Иргэдийн хандлага


- Нэг талаас ажил олгогчид залуучуудын эрийг мохоож, нөгөө талаас залуучууд хурдан баяжих хүсэлтэй байна.
- Тэтгэмж нь хөдөлмөр эрхлэх шийдвэр гаргалтад нөлөөлдөггүй гэв.





Дүгнэлт, зөвлөмж

# ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ



# Дүгнэлт, зөвлөмж

Өрхийн ерөнхий шинж чанарын  
талаарх дүгнэлт



## Өрхийн гишүүд

Ам бүл олон, олон хүүхэдтэй  
3 өрх тутмын нэг нь хөгжлийн  
бэрхшээлтэй гишүүнтэй



## Орлого

Дийлэнх өрхийн тэргүүнүүд идэр насны,  
мэргэжил, үр чадвар доогуур  
Нийт өрхийн 80.8 хувь нь цалингийн  
орлоготой буюу хөдөлмөрлөх, орлогоо  
нэмэгдүүлэх зорилготой



## Зөвлөмж

“Хүнс тэжээлийн дэмжлэг, туслалцаа” хөтөлбөр болон  
зорилтот өрхөд хандсан бусад халамжийн  
хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх (Асаргааны тэтгэмж,  
хүүхдийн мөнгөн тэтгэмж, эх, эцэг, олон хүүхэдтэй өрх  
толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох зэрэг)  
Зорилтот өрхийн газар эзэмших, өмчлөх боломжийг  
нэмэгдүүлэх



## Хөдөлмөр эрхэлж байгаа гишүүдийн талаарх дүгнэлт, зөвлөмж



1

Хөдөлмөр эрхлэлт насны бүх ангилал улсын дундажаас доогуур, 15-24 насны залуусын хөдөлмөр эрхлэлт хамгийн бага, 25-44 насны эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр 45-55 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр Хөдөлмөр эрхэлдэг гишүүний 60% нь байнгын ажилтай, үлдэх хувь нь улирлын чанартай түр, цалин хөлстэй тохиолдлын ажил эрхэлдэг болон дадлагажигч хийдэг

2

Барилга болон үйлчилгээний салбарт энгийн ажил, мэргэжлээр ажилладаг Долоо хоногт дундажаар 51 цаг ажилладаг ба сарын дундаж цалин 946,078 төгрөг байдаг, Сарын дундаж цалин нь 2023 оны 2 дугаар улирлын статистикаар зарлагдсан нийт дундаж цалингаас 50 хувиар, энгийн ажил, мэргэжлээр ажиллагчдынхаас 33 хувиар доогуур

3

1-2 гишүүн нь хөдөлмөр эрхэлдэг өрхийн цалин хөлсний дундаж орлого 1 ажилчны дундаж цалин хөлсний орлого (2023 оны 2 дугаар улирлын статистикаар 1.89 сая төгрөгөөр мэдээлэгдсэн)-оос доогуур

Хөдөлмөр эрхэлдэг гишүүдийн тал хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй буюу даатгалд төдийлөн ач холбогдол өгдөггүй

### Зөвлөмж

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Хөдөлмөрийн насны иргэдийн үр чадварыг нэмэгдүүлэх

Хөдөлмөр эрхлэгч иргэдийг ажлын байранд тогтвортой ажиллахад нь дэмжих

Нийгмийн даатгалын ач холбогдлыг ухуулах



## Дүгнэлт

1

Судалгаанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлээгүй нь хөдөлмөр эрхэлдгээс илүү олон

Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хувьд эрүүл мэндийн байдлаасаа шалтгаалан ажиллах боломжгүй байдаг

Хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүн эсвэл бага насны хүүхдээ асрах болон олон хүүхдээ харж, халамжлах хэрэгцээ шаардлагын улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй байдаг

2

Асрахуйн ажил хийх гол үүрэг нь залуу эмэгтэйчүүдэд ногдож байгаа бөгөөд хүүхдээ асрах, ар гэрээ авч явах үүрэг хариуцлага нь тэдгээрийн хөдөлмөр эрхлэх боломжийг нь хязгаарладаг

Харин хөдөлмөр эрхлэх боломжтой ч ажиллах сонирхолгүй иргэд төдийлөн олон биш байдаг

Ажиллах сонирхолгүй иргэдэд мэргэжил, үр чадвар олгохоос илүү өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, алсын хараа, зорилгоор удирдуулах, хамт олонтой болох, бусадтай хамтран ажиллах зэргийг дэмжсэн сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө чухал

3

Ажил хайсан ч олж чадахгүй байгаа иргэдийн хувьд нас болон ажлын байранд тавигдах шаардлагад тэнцэхгүй байх зэргээр тохирох ажлын байраа олоход нэлээд бэрхшээл тулгардаг

Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тал орчим хувь нь өмнө нь ажил эрхэлж байгаагүй Уг бүлгийнхний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь салбарын байгууллагуудаас ихээхэн хүчин чармайлт шаардах талтай

## Зөвлөмж

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааг оновчтой болгох

Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт дээр анхаарах

Салбарын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах

Аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах

Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих



Хөдөлмөр  
эрхлэхгүй байгаа  
шалтгаан

# Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж



Ажил олгогчид ажлын байрыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй эмэгтэйчүүд, ахмадууд болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд нь иргэдэд танил байсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажил, үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг ойлголт сул, цаашлаад энэ төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжийн талаарх итгэл, үнэмшил муу Анхан шатанд ажиллаж буй мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн ажил цаг бага зарцуулдаг, мэргэжилтнүүдийн чадавх зарим талаар сул, суралцах цаг завгүй, байнга солигддог



Төрөөс баримталж буй төсөл, хөтөлбөрүүд нь анхан шатны нэгжийн судалгаан дээр үндэслэгддэггүй, хэрэгжих шатандаа дамжлага ихтэй, санхүүжилт нь уддаг, үйл ажиллагаа ихтэй үр дүн нь тодорхой бус, Нэг орон нутагт хэрэгжиж төсөл, хөтөлбөрүүд нь уялдаа, хамтын ажиллагаа сул Ажлын байранд хэт өндөр шаардлага тавьдаг, иргэдтэй хуулийн дагуу гэрээ байгуулдаггүй эсвэл гэрээний үүргээ биелүүлдэггүй, ажлын цаг урт, ажлын үнэлгээ бага зэрэг асуудал тулгардаг Өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг хэрэгтэй ч, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлага, нөөц болон оролцогчдын тоо хязгаарлагдмал байдлын улмаас хамрагдах боломжгүй болдог



## **Зөвлөмж**

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааг оновчтой болгох Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт дээр анхаарах Салбарын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах Аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих



# Өрхийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлстэй холбоотой дүгнэлт, зөвлөмж



Өрхийн орлого нь ихэнх өрхийн хувьд цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд медиан утга нь 1,604,333 төгрөг ба өрхүүдийн орлогын хэмжээ ялгаа ихтэй, цалингийн орлого өрхийн нийт орлогын 49.9 хувийг, нийт орлогын 36.3 хувийг эзэлж буй тэтгэмжийн орлого эзэлдэг. Ялгаа бүхий орлогод өрхийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, өрх толгойлсон эцэг/эхтэй байдал, өрхийн тэргүүний ажил эрхлэлт болон хүйс, сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо болон бага насны хүүхдийн тоо нөлөөлдөг.



Загварчлалын үр дүнгээр тэтгэврийн насны гишүүний тоо нь орлогын хэмжээ болон орлогын өсөлтийн хэмжээнд нөлөөтэй. Орлогын өөрчлөлтийн хэмжээ нь тэтгэмжийн орлогын өөрчлөлт, хөдөлмөрийн насны гишүүний тооноос хамаардаг. Нэгээс дээш тооны гишүүн нь ажил эрхэлдэг бол өрхийн цалин хөлсний орлого, нийт орлого төдийгүй нэг гишүүнд ногдох орлого нь нийт өрхийн дунджаас өндөр.



Хөдөлмөр эрхэлдэг 2-3 гишүүнтэй, өөрийн бизнестэй цөөн тооны өрхийн хувьд орлого өндөртэй. Өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг бол цалин хөлсний орлого, нийт орлого болон нэг гишүүнд ногдох тогтмол бус орлого зэрэг нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхийнхөөс өндөр. Эрэгтэй тэргүүнтэй өрхийн хувьд цалин хөлсний орлого, нийт орлого нь эмэгтэй тэргүүнтэй өрхийн орлогоос тус бүр өндөр.

# Өрхийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлстэй холбоотой дүгнэлт, зөвлөмж



Өрх толгойлсон эцэг, эхтэй өрхийн тэтгэмжийн орлого болон мөнгөн тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь хамтын амьдралтай өрхийнхөөс өндөр

Өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй бол тэтгэмжийн нийт орлогод эзлэх хувь өндөр

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тэтгэмжийн орлого, түүний нийт орлогод эзлэх хувь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрхийнхөөс тус тус өндөр



Өөрийн аж ахуйгаас болон бусдаас үнэгүй хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ нь өрхийн нийт орлогын өөрчлөлтөд төдийлэн нөлөө үзүүлэхгүй байгаа боловч өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүний үнэлгээ нь өрх толгойлсон эцэг, эхтэй өрхөөс хамтын амьдралтай өрхөд өндөр

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрхөд хөдөө ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого өндөр байх хандлагатай

Өрхийн хөдөлмөр эрхэлж буй гишүүн, тэтгэвэр авдаг ахмад настан болон бага насны хүүхдийн тоо, төрөөс хүлээн авдаг тэтгэмжийн хэмжээ нэмэгдэхэд өрхийн орлого нэмэгддэг

Нийт орлогод хамгийн их нөлөө үзүүлэх хувьсагч нь хөдөлмөр эрхэлж буй гишүүний тоо буюу өрхийн хөдөлмөр эрхэлж буй гишүүн олон байхад нийт орлого нэмэгддэг



## **Зөвлөмж**

*Хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх*

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, өрхийн орлогыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ бүхий олон улсын сайн туршлагаас суралцах (БРАК-ийн Төгсөлтийн аргачлал зэрэг)



## БРАК-ийн Төгсөлтийн аргачлал

- Хамгийн их ядууралд өртсөн, нийгэмдээ гадуурхагдсан, амьжиргаа доогуур гэр бүлүүдэд баталгаагүй орлогын эх үүсвэрээс илүү тогтвортой орлого бий болгох үйл ажиллагаанд шилжих боломжийг олгодог
- Олон улсад төгсөлтийн аргачлалыг бизнесийн байгууллагуудад хүний нөөцийн бодлоготойгоо хослуулан хэрэглэх зөвлөгөөг өгдөг
- Ядууралд өртсөн өрх бүрт уг аргачлал зориулагдсан, харин тодорхой тооны өрхүүдийн нийтлэг онцлог, ядуурлын шалтгаанд тулгуурлан аргачлалыг тохируулах боломжтой
- Манай орны хувьд аргачлалыг хэд хэдэн орон нутагт хэрэгжүүлж үзсэн туршлагатай. Цаашид энэхүү аргачлалын үр дүнг хэлэлцэж, өөрийн орны онцлог, ядууралд өртсөн өрхүүдэд тулгамдаж буй нийтлэг бэрхшээлийг арилгахад чиглэсэн загвар хөтөлбөрийг тохируулан боловсруулах боломжтой

# Өрхийн хөдөлмөрийн насны гишүүний ажил эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлстэй холбоотой дүгнэлт, зөвлөмж



Өрхийн гишүүний ажил эрхлэх эсэх нь боловсрол, нас, өрхийн гишүүний статус зэргээс хамаардаг  
Идэр насны гишүүд болон өрхийн тэргүүн, түүний эхнэр/нөхрийн хөдөлмөр эрхлэх хандлага өндөх Боловсролтой байдал нь ажил эрхлэлтэд эерэг нөлөө



Дүүргийн онцлогоос шалтгаалан иргэдийн ажил эрхлэх магадлал ялгаатай  
Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн сүүлийн нэг жилд ажил эрхлэх эсэхэд дүүрэг, хороонд ажил хайгчаар бүртгүүлсэн байдал болон нийгмийн даатгалын төлөлтийн хэлбэр нь нөлөөтэй



## **Зөвлөмж**

Зорилтот өрхийн гишүүдийн боловсролд анхаарах  
Гэр бүлийн харилцаа, өрхийн хөгжлийн сургалт, зөвлөгөө явуулах  
Хөдөлмөрийн насны иргэдийг ажил хайгчаар бүртгэх

# Ерөнхий дүгнэлт

- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, цаашид хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан өрхийн амьжиргааг дэмжих боломжуудыг тодорхойлсон.
- Өрхийн шинж чанар, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, өрхийн орлогын хэмжээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалснаар тус үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжуудыг тодорхойлсон.
- Өрхүүдийн дийлэнх нь амьжиргаа доогуур, олон хүүхэдтэй, цөөнгүй өрх нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй ба уг бүлэгт ажилгүйдлийн түвшин өндөр байсан.
- Ажилгүйдлийн нийтлэг шалтгаан нь эрүүл мэндийн асуудал, асрахуйн ажил эрхэлдэг болон ажил олдохгүй байгаа гэх судалгааны үр дүнгүүд нь өмнө хийгдсэн судалгааны үр дүнтэй нийцэж байгаа боловч зарим үр дүнгүүд нь ялгаатай байсан.
- Тухайлбал, Ц.Амартүвшин нарын “Хүнсний тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрагдалт ба ажил эрхлэлт” судалгаа нь хот, хөдөөгийн иргэдийг хамруулсан бөгөөд хөдөөд ажилгүйдлийн түвшин хотынхоос их байгааг онцолсны зэрэгцээ эрчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр, ядуурал нь ажилгүйдэлтэй холбоотой байх албагүй, харин бага цалинтай ажил, өрхийн тусгай хэрэгцээтэй (олон хүүхэдтэй, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт асран халамжлах гишүүдтэй том өрхүүд) холбоотой гэсэн үр дүнг танилцуулсан.




# Ерөнхий дүгнэлт

- Бид судалгаандаа зөвхөн нийслэлийн дүүргүүдийг хамруулсан учир эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр, өрхийн орлогогүй байдалд ажилгүйдэл, ялангуяа хөдөлмөрийн насны иргэдийн ажил эрхлэх боломж хязгаарлагдмал байдал нь хамгийн ихээр нөлөөлж байна гэж тодорхойлогдсон нь өмнөх судалгааны үр дүнгээс ялгаатай байсан.
- Ядууралд бага цалинтай ажил, өрхөд тулгамдаж буй нийгмийн асуудлууд нөлөөлж буй үр дүн нь Амартүвшин нарын судалгааны үр дүнтэй нийцсэн.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжуудыг санал болгохдоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих одоогийн үйл ажиллагаануудын талаарх иргэдийн мэдлэг, ойлголт болон тэдгээрийн санал хүсэлтийг судалж, нөгөө талаас томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх экспертүүдийн үнэлгээ ба цаашид анхаарах асуудлуудыг гүнзгийрүүлэн судалсан нь ололттой байсан.
- Нийгмийн хамгааллын салбарын байгууллагууд, хөтөлбөр хэрэгжүүлэгч нар үйл ажиллагаагаа төлөвлөхдөө энэхүү судалгааны үр дүнг харгалзан үзэх боломжтой юм.

**А н х а а р а л х а н д у у л с а н д**  
**б а я р л а л а а**

**Д. Больтогтох, Б. Бадамхүү,  
Ж. Номин-Эрдэнэ**

 99098575, 88096189, 88980246

 [bolitogtokh.d@ufe.edu.mn](mailto:bolitogtokh.d@ufe.edu.mn)  
[badamhuu.b@ufe.edu.mn](mailto:badamhuu.b@ufe.edu.mn)  
[jnominerdene@gmail.com](mailto:jnominerdene@gmail.com)